| 210501                | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                           | 194,325,200.00        | 187,276,488.11   | 7,048,711.89   | 96.4  |
| 210502                | Хоол, хүнс  | 57,397,800.00         | 58,661,900.00    | (1,264,100.00) | 102.2 |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                               | 10,541,400.00         | 9,603,300.00     | 938,100.00     | 91.1  |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                  | 54,326,600.00         | 50,064,090.00    | 4,262,510.00   | 92.2  |
| 210601                | Багаж, техник, хэрэгсэл                                   | 19,656,200.00         | 19,666,040.00    | (9,840.00)     | 100.1 |
| 210604                | Урсгал засвар   | 34,670,400.00         | 30,398,050.00    | 4,272,350.00   | 87.7  |
| <b>2107</b>           | <b>Томиллолт, зочны зардал</b>                            | 4,620,000.00          | 3,724,000.00     | 896,000.00     | 80.6  |

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|             |   |                  |                      |                        |          |
|-------------|---|------------------|----------------------|------------------------|----------|
| 210702      | Дотоод албан томилолт   | 4,620,000.00     | 3,724,000.00         | 896,000.00             | 80.6     |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 4,867,400.00     | 4,686,625.00         | 180,775.00             | 96.3     |
| 210803      | Даатгалын үйлчилгээ   | 449,000.00       | 412,750.00           | 36,250.00              | 91.9     |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар                                      | 320,000.00       | 312,675.00           | 7,325.00               | 97.7     |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                   | 50,000.00        | 47,100.00            | 2,900.00               | 94.2     |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 | 2,831,100.00     | 2,831,100.00         | -                      | 100.0    |
| 210807      | Газрын төлбөр   | 120,400.00       | -                    | 120,400.00             | -        |
| 210809      | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх                          | 1,096,900.00     | 1,083,000.00         | 13,900.00              | 98.7     |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | 94,507,000.00    | 94,502,435.00        | 4,565.00               | 100.0    |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                 | 94,507,000.00    | 94,502,435.00        | 4,565.00               | 100.0    |
|             | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | 2,119,102,600.00 | 1,974,999,794.61     | 144,102,805.39         | 93.2     |
| <b>1320</b> | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                           | 92,359,800.00    | 85,017,680.62        | 7,342,119.38           | 92.1     |
| 132001      | Орон нутгийн төсвөөс  | 92,359,800.00    | 85,017,680.62        | 7,342,119.38           | 92.1     |
| <b>1340</b> | <b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>             | 2,026,742,800.00 | 1,889,982,113.99     | 136,760,686.01         | 93.3     |
| 134002      | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих                       | 2,026,742,800.00 | 1,889,982,113.99     | 136,760,686.01         | 93.3     |
| <b>4</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>         |                  | <b>29,578,365.26</b> | <b>(29,578,365.26)</b> | <b>-</b> |
| <b>5</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>        |                  | <b>226,355.14</b>    | <b>(226,355.14)</b>    | <b>-</b> |
| <b>62</b>   | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>   | 44               | 44                   | -                      | 100.0    |
| 620001      | Удирдах ажилтан   | 1                | 1                    | -                      | 100.0    |
| 620002      | Гүйцэтгэх ажилтан   | 36               | 36                   | -                      | 100.0    |
| 620003      | Үйлчлэх ажилтан   | 7                | 7                    | -                      | 100.0    |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв нь сумын ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь эмнэлгийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай, үзүүлэх үйлчлүүлэгчийн эрхийг дээдлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай /Шинэчилсэн найруулга/
- Засгийн газрын 2024.02.28-ний өдрийн Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 84 дүгээр тогтоол,
- Засгийн газрын 2024.03.27-ний өдрийн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 05 дугаар тогтоол,
- Эрүүл мэндийн үндэсний зөвлөл (ЭМҮЗ)-ийн 2024 оны Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 06 дугаар тогтоол.

Баян-Өлгий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/14 тоот тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 377,502.9 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт            | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
|---------------------|--------------------|--------------------|------------------|
| Б                   | 1                  | 2                  | 3=2-1            |
| Мөнгөн хөрөнгө      | 29,578.4           | 226.4              | (29,352.0)       |
| Авлага              | 23,983.9           | 259,141.8          | 235,157.9        |
| Бараа материал      | 116,995.5          | 158,611.4          | 41,615.9         |
| Үндсэн хөрөнгө      | 1,169,011.9        | 1,299,093.1        | 130,081.2        |
| <b>Нийт хөрөнгө</b> | <b>1,339,569.7</b> | <b>1,717,072.7</b> | <b>377,503.0</b> |
| Өр төлбөр           | -                  | 67,410.7           | 67,410.7         |

|  |                    |                    |                  |
|--|--------------------|--------------------|------------------|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 1,339,569.7        | 1,649,661.9        | 310,092.2        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>1,339,569.7</b> | <b>1,717,072.6</b> | <b>377,502.9</b> |

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 29,352.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд 1,975,012.1 мянган төгрөгийн санхүүжилт авч 1,979,998.5 мянган төгрөгийг үйл ажиллагаанд, 24,365.6 мянган төгрөгийг хөрөнгө оруулалтад зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Авлагын дансны үлдэгдэл 259,141.8 мянган төгрөг болж 235,157.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 2,125,140.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,889,982.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 158,611.4 мянган төгрөг болж 41,615.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 35,670.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, урсгал санхүүжилтээс 518,478.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 512,533.3 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,299,093.1 мянган төгрөг болж, 130,081.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 249,269.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 24,365.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч 143,554.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 67,410.7 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт дутуу авсантай холбоотой байгууллагад төлөх нийгмийн даатгалын шимтгэл, түлш, норматив зардлын өглөг 67,410.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 1,649,661.9 мянган төгрөг болж 310,092.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлан оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,026,742.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 92,359.8 мянган төгрөг, нийт зарлагыг 2,119,102.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,260,890.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 157,611.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 92359,8 мянга, хангамж, бараа материалын зардлыг 145,317,4 мянга, норматив зардлыг 249079,4 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 4262,0 мянга, томилот, зочны зардлыг 0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2100 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 180,7 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн хэмнэлт гаргахыг зорьсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71602 хөтөлбөрийн 80302 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,364,056.7 мянган төгрөг, 81603 арга хэмжээний 555,277.4 төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний орлогоос, орон нутгийн санхүүжилтээс 85,017.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 1,889,982.1 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 85,030.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, оны эхний үлдэгдлээс 29,578.3 мянган төгрөг нийтдээ 1,975,012.1 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлж, үйл ажиллагаа явуулсан байна. Зарцуулагдаагүй 226.0 мянган төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,004,125.4 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа зарим зардлыг төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

|                 |   |                    |                    |                  | /мянган төгрөгөөр/ |  |
|-----------------|---|--------------------|--------------------|------------------|--------------------|--|
| д/д             | Хөтөлбөр, арга хэмжээ                       | Төлөвлөгөө         | Гүйцэтгэл          | Зөрүү            | Биелэл<br>т хувь   |  |
| 1               | 71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ           |                    |                    |                  |                    |  |
| 1.1             | 80302 Нэг иргэнд ноогдох норматив           | 1,438,792.9        | 1,364,056.7        | 74,736.2         | 94.8               |  |
| 1.2             | 81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ   | 587,949.9          | 555,277.4          | 32,672.5         | 94.4               |  |
| 1.3             | 71601 Нийгмийн эрүүл мэнд                   |                    |                    |                  |                    |  |
| 1.4             | 80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 92,359.8           | 85,017.7           | 7,342.1          | 92.1               |  |
| <b>Нийт дүн</b> |   | <b>2,119,102.6</b> | <b>2,004,351.8</b> | <b>114,750.8</b> | <b>94.6</b>        |  |

Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 94.6 хувийн биелэлттэй байна. Тухайн төсвийн жилд нэмэлт санхүүжилт аваагүй болно.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

2024 оны төсвийн жилд 518,478.7 мянган төгрөгийн бараа материал, 26,460.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авалтын хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Лайт энд Дилайт Аудит” ХХК-ийн аудитор Л.Мөнхцэцэг гүйцэтгэж, аудитын менежер Ц.Төмөрсүх, компанийн захирал М.Нурболат нар анхан шатны чанарын хяналтыг, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,575,714.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 23,635.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллаа явуулсан байна.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 3 зөрчилд акт, зөвлөмж өглөө.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 14 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнгэл сумын эрүүл мэндийн төв нь нийт 1,670,932.2 мянган төгрөгийн 39 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 104,015.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн нь 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт        | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт  |                  |              |
|-----------------|------------------------|------------------|----------|------------------|--------------|
|                 | Тоо                    | Дүн              | Тоо      | Дүн              | Хувь         |
| Зөвлөмж         | 1                      | 81,783.9         | 1        | 81,783.9         | 100.0        |
| Албан шаардлага | 2                      | 22,231.4         | 2        | 22,231.4         | 100.0        |
| <b>Нийт дүн</b> | <b>3</b>               | <b>104,015.3</b> | <b>3</b> | <b>104,015.3</b> | <b>100.0</b> |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,678.0 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, цалин хөлс буруу тооцож олгосон 794.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, батлагдсан 103,972.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тээвэр шатахуун, 59,521.5 мянган төгрөгийн төсөвтэй хоол хүнсийг худалдан авалт хийхдээ худалдан авалтын төлөвлөгөө боловсруулаагүй, шууд худалдан авалт хийсэн болон жилийн эцсийн байдлаар нийт 20,283.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, өмнөх онд харилцагчаас ирүүлсэн 600.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг өглөг үүсгээгүй, аккруел сууриар бүртгээгүй зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 794.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ний өдрийн Б/02 дугаар тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл оногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 09 дугаар сарын 25-ний өдрийн 51 дугаар тушаалаар ажилтанд 294.2 мянган төгрөгийн урамшуулалт цалин, 05 дугаар сарын цалингийн цэсээр ажилтанд 500.0 мянган төгрөгийн цалин илүү олгож, тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 6.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно.”, 123.9 “Ажил олгогч энэ хуулийн 123.8-д заасан хугацаанаас өмнө ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцож болох бөгөөд энэ тухай ажилтанд бичгээр мэдэгдэнэ”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт 3 “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.7 “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалин хөлсийг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (ТБОНӨБАҮХАТ)-ийн 44 дүгээр зүйлийн 44.1 “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”,

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.5 "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 45 дугаар зүйлийн 45.3. "Энэ хуулийн 45.2-т заасан жагсаалтад хамаарахгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд төсвийн шууд захирагч захиалагч байна", Засгийн газрын 2025 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

## **2. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажихтай холбоотой асуудал**

### 2.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн нийт 20,283.8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагуудтай тооцооны үлдэгдлийг тайлант хугацаа бүр тооцоо нийлж баталгаажуулж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

## **3. Нягтлан бодох бүртгэлийг аккруел сууриар хөтлөөгүй, харилцагчийн тооцоог дутуу бүртгэсэн.**

### 3.1. Илрүүлэлт:

Өмнөх тайлант онд харилцагчаас ирүүлсэн 600.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг өглөг үүсгээгүй, аккруел сууриар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

### 3.2. Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагаас худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээний нэхэмжлэхийг төлбөр төлсөн эсэхээс үл хамаарч хүлээн зөвшөөрөх шалгуур хангасан үед бүртгэлд тусгаж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Алдааны нэгтгэл

| Алдааны товч утга   | Нийт алдаа |              | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |              | Буруу тусган илэрхийлсэн |          | Үүнээс     |          |              |          |                    |              |
|---|------------|--------------|-----------------------------------|--------------|--------------------------|----------|------------|----------|--------------|----------|--------------------|--------------|
|   | Тоо        | Дүн          | Тоо                               | Дүн          | Тоо                      | Дүн      | Залруулсан |          | Залруулаагүй |          | Зөвлөмж<br>Тоо Дүн |              |
|   |            |              |                                   |              |                          |          | Тоо        | Дүн      | Тоо          | Дүн      |                    |              |
| Өмнөх онд харилцагчаас нэхэмжлэхийг өглөг үүсгээгүй, акруел сууриар бүртгээгүй байна. | 1          | 600.0        | 1                                 | 600.0        | -                        | -        | -          | -        | -            | -        | 1                  | 600.0        |
| <b>ДҮН</b>  | <b>1</b>   | <b>600.0</b> | <b>1</b>                          | <b>600.0</b> | <b>1</b>                 | <b>-</b> | <b>-</b>   | <b>-</b> | <b>-</b>     | <b>-</b> | <b>1</b>           | <b>600.0</b> |

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                 | Төлбөрийн акт |              | Албан шаардлага |          | Зөвлөмж  |          |          |                 | Хариуцлага тооцуулах албан шаардлага |          | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|---|-------------|-----------------|---------------|--------------|-----------------|----------|----------|----------|----------|-----------------|--------------------------------------|----------|---|----------|
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн          | Тоо             | Дүн      | Тоо      | Дүн      | Тоо      | Дүн             | Тоо                                  | Дүн      | Тоо   | Дүн      |
|   |             |                 |               |              |                 |          |          |          |          |                 |                                      |          |   |          |
| Тайлант хугацаанд ажилтанд цалин илүү олгосон, сахилгын шийтгэлтэй байх хугацаанд урамшуулал олгосон. | 1           | 794.2           | 1             | 794.2        | -               | -        | -        | -        | -        | -               | -                                    | -        | -   | -        |
| Тайлант хугацаанд худалдан авалтын төлөвлөгөө боловсруулаагүй, шууд худалдан авалт хийсэн.            | 1           | -               | -             | -            | -               | -        | -        | -        | 1        | -               | -                                    | -        | -   | -        |
| Жилийн эцсийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.                      | 1           | 20,283.8        | -             | -            | -               | -        | -        | -        | 1        | 20,283.8        | -                                    | -        | -   | -        |
| <b>ДҮН</b>  | <b>3</b>    | <b>21,078.0</b> | <b>2</b>      | <b>794.2</b> | <b>-</b>        | <b>-</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>2</b> | <b>20,283.8</b> | <b>-</b>                             | <b>-</b> | <b>-</b>  | <b>-</b> |

/мянган төгрөгөөр/